



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/39/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

П.Амаржаргал

Утас: 88106992

Цахим хаяг: amar_802002@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ӨЛЗИЙТ СУМЫН ИТХ-ЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.НАРАНТУЯА ТАНАА

2019.02.25 № 2/109
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон

D:\Amaraa\amaraa\2019\olziit ITH\tailagnal\Өлзийт сумын ИТХ Аудитын гэрчилгээ.docx

2519203

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Өлзийт сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Нарантуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 19-нөөс 2019 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 106 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өлзийт сумын ИТХ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Өлзийт сумын ИТХурал нь “ Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, төлөвшүүлэн сум орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлэх ард ирэгдийнхээ төлөөлөх эрхийг ханган ажиллах ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Өлзийт сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, төлөвшүүлэх

Өлзийт сумын ИТХ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Өлзийт сумын ИТХ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Өлзийт сумын ИТХ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Өлзийт сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Өлзийт сумын ИТХ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 77

78,2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1,5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

2.8.1.1

Байхгүй

2.8.1.2

Байхгүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өлзийт сумын ИТХ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 72,3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв,

гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 72,2 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь 2018 онд 72,2 сая төгрөгийн санхүүжилт авч урсгалд үйл ажиллагааны зардал зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Өлзийт сумын ИТХ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан боловч төсөв гүйцэтгэлтэй холбоотой Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) байршуулах мэдээллийг 1,2,10-р сарууд, 3-р улиралд хугацаа хоцруулан мэдээлсэн, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) мэдээллийг 7-р сард, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) мэдээллийг 2,7,8-р саруудад хугацаа хоцрон мэдээлсэн, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой мэдээллээс Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 2,3,10-р саруудад, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 1,2,3,4,7-р саруудад, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) 1,3,10-р саруудад, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) 4-р улиралд тус бүр хугацаа хоцрон мэдээлсэн байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,649,600.00</u>	<u>2,815,100.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,649,600.00	2,815,100.00
351	Түүхий эд материал	1,100,000.00	1,100,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,100,000.00	1,100,000.00
354	Хангамжийн материал	1,549,600.00	1,715,100.00
35410	Бичиг хэргийн материал	639,100.00	804,600.00
35420	Аж ахуйн материал	349,400.00	349,400.00
35470	Бусад хангамжийн материал	561,100.00	561,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,552,558.70</u>	<u>6,079,828.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,552,558.70	6,079,828.73
392	Биет хөрөнгө	14,552,558.70	6,079,828.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,900,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,911,933.28	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,487,870.00	8,187,770.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,487,870.00	-3,501,203.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,932,400.00	4,989,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,367,908.02	-3,595,737.93
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>17,202,158.70</u>	<u>8,894,928.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>141,528.00</u>	<u>258,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	141,528.00	258,500.00
413	Өглөг	141,528.00	258,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	141,528.00	258,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>17,060,630.70</u>	<u>8,636,428.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	17,060,630.70	8,636,428.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,324,120.00	12,324,120.00
51101	Өмч: - төрийн	12,324,120.00	12,324,120.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,502,910.70	-3,921,291.27
51210	Өмнөх үеийн үр дүн	4,502,910.70	4,502,910.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,424,201.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	233,600.00	233,600.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>17,202,158.70</u>	<u>8,894,928.73</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>80,973,800.00</u>	<u>80,712,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>7,700.00</u>	<u>2,504,900.00</u>

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120	Нийтлэг татварын бус орлого	7,700.00	2,504,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,700.00	2,499,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,700.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	2,499,900.00
120009	Бусад орлого	00.00	5,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	80,966,100.00	78,207,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	5,867,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	5,867,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,966,100.00	72,340,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,966,100.00	72,340,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	85,478,929.20	77,560,601.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,478,929.20	77,560,601.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,307,430.20	70,192,171.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,834,479.00	40,230,257.07
210101	Үндсэн цалин	36,234,479.00	38,430,257.07
210104	Урамшуулал	3,600,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,175,260.00	4,619,119.93
210201	Тэтгэврийн даатгал	2,581,241.00	3,059,772.96
210202	Тэтгэмжийн даатгал	318,804.00	397,087.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	398,505.00	317,669.90
210204	Ажилгүйдлийн даатгал	79,701.00	76,781.00
210205	Эрүүл мэндийн даатгал	797,009.00	767,808.96
2104	Хангамж, бараа материалын зардал	22,041,456.00	7,129,565.00
210401	Бичиг хэрэг	2,868,100.00	1,203,459.00
210402	Тээвэр, шатахуун	17,059,700.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	227,040.00	426,106.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,590,000.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	296,616.00	00.00
2105	Нормативт зардал	2,829,000.00	00.00
210502	Хоол, хүнс	2,829,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	652,900.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	652,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,364,500.00	1,414,500.00
210702	Дотоод албан томилолт	1,364,500.00	1,414,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,000.00	626,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	280,000.00	626,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,517,735.20	15,519,629.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,413,400.00	12,733,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	133,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,104,335.20	2,652,829.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,171,499.00	7,368,430.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,611,600.00	1,400,000.00

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	559,899.00	5,968,430.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	559,899.00	101,430.00
213404	Хөрөнгийн	00.00	5,867,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4,505,129.20	3,152,198.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	11,576,400.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	11,576,400.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-11,576,400.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,505,129.20	-8,424,201.97

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	80,973,800.00	78,212,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,700.00	5,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,700.00	5,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,700.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,700.00	00.00
120009	Бусад орлого	00.00	5,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	80,966,100.00	78,207,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	5,867,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	5,867,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,966,100.00	72,340,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,966,100.00	72,340,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	80,973,800.00	78,212,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,973,800.00	78,212,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,802,301.00	70,844,470.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,850,451.00	40,112,241.00
210101	Үндсэн цалин	36,250,451.00	36,812,241.00
210104	Урамшуулал	3,600,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,017,760.00	4,620,164.00
210201	Тэтгэврийн даатгал	4,017,760.00	3,017,723.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	394,966.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	323,403.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	80,729.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	803,343.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,996,990.00	2,975,065.00

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	316,200.00	990,065.00
210402	Тээвэр, шатахуун	1,245,000.00	1,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	565,000.00
210404	Ном, хэвлэл	185,790.00	120,000.00
2105	Нормативт зардал	300,000.00	791,000.00
210502	Хоол, хүнс	300,000.00	791,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	3,909,500.00
210602	Тавилга	00.00	3,256,600.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	652,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,364,500.00	1,414,500.00
210702	Дотоод албан томилолт	1,364,500.00	1,414,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,065,000.00	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,007,600.00	16,722,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,007,600.00	15,722,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,171,499.00	7,368,430.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,611,600.00	1,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,611,600.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	559,899.00	5,968,430.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	559,899.00	101,430.00
213404	Хөрөнгийн	00.00	5,867,000.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,324,120.00	233,600.00	4,502,910.70	00.00	17,060,630.70
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,324,120.00	233,600.00	4,502,910.70	00.00	17,060,630.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,324,120.00	233,600.00	4,502,910.70	00.00	17,060,630.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,424,201.97	00.00	-8,424,201.97
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,324,120.00	233,600.00	-3,921,291.27	00.00	8,636,428.73

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	79,966,100.00	79,406,201.00	72,292,900.00	72,239,470.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	79,966,100.00	79,406,201.00	72,292,900.00	72,239,470.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,354,500.00	73,794,601.00	70,892,900.00	70,839,470.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,018,400.00	39,850,451.00	40,147,900.00	40,112,241.00
210101	Үндсэн цалин	36,418,400.00	36,250,451.00	36,847,900.00	36,812,241.00
210104	Урамшуулал	3,600,000.00	3,600,000.00	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	3,300,000.00	3,300,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,402,000.00	4,017,760.00	4,633,800.00	4,620,164.00
210201	Тэтгэврийн даатгал	2,801,200.00	4,017,760.00	3,030,172.00	3,017,723.00
210202	Тэтгэмжийн даатгал	379,500.00	00.00	399,200.00	394,966.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	340,800.00	00.00	321,200.00	323,403.00
210204	Ажилгүйдлийн даатгал	80,100.00	00.00	80,300.00	80,729.00
210205	Эрүүл мэндийн даатгал	800,400.00	00.00	802,928.00	803,343.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,997,000.00	1,989,290.00	2,987,000.00	2,965,065.00
210401	Бичиг хэрэг	322,000.00	308,500.00	1,002,000.00	985,065.00
210402	Тээвэр, шатахуун	1,245,000.00	1,245,000.00	1,300,000.00	1,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	250,000.00	565,000.00	565,000.00
210404	Ном, хэвлэл	180,000.00	185,790.00	120,000.00	120,000.00
2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00	791,100.00	791,000.00
210502	Хоол, хүнс	300,000.00	300,000.00	791,100.00	791,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00	3,916,600.00	3,909,500.00
210602	Тавилга	00.00	00.00	3,256,600.00	3,256,600.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	660,000.00	652,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,364,500.00	1,364,500.00	1,414,500.00	1,414,500.00
210702	Дотоод албан томилолт	1,364,500.00	1,364,500.00	1,414,500.00	1,414,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,000.00	65,000.00	280,000.00	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,000.00	65,000.00	280,000.00	280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	00.00	20,000.00

Өлзийт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25007600.00	25007600.00	16722000.00	16722000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,007,600.00	25,007,600.00	15,722,000.00	15,722,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5611600.00	5611600.00	1400000.00	1400000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,611,600.00	5,611,600.00	1,400,000.00	1,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,011,600.00	00.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	5,611,600.00	1,400,000.00	1,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	79,966,100.00	79,406,201.00	72,292,900.00	72,239,470.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,966,100.00	79,406,201.00	72,292,900.00	72,239,470.00
132001	Орон нутгийн төсвөөс	77,966,100.00	79,406,201.00	72,292,900.00	72,239,470.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	00.00	00.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,000,000.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	03.00	03.00	03.00	03.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	01.00	01.00